


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
УДИРДЛАГЫН АКАДЕМИ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
УДИРДЛАГЫН АКАДЕМИ



МЭНДЧИЛГЭЭ

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн түүх бол Монгол төрийн түүхийн салшгүй хэсэг мөн. Төр оршихуй дор эрдэм боловсролтой, мэргэшсэн төрийн албаны сургалт, зөвлөх үйлчилгээ жам ёсоор зайлшгүй оршдог. Харин түүхийн үе бүхэн өөрийн онцлогт тохирсон төрийн албаны сургалтын тогтолцоо, зөвлөх үйлчилгээний хэлбэртэй байсан нь зүйн хэрэг. Дэлхийн түүхийг шинэчилсэн XX зууны их өөрчлөлт шинэчлэл Монгол улсыг тойроогүй.

Энэ их өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд Монгол улс өөрийн тусгаар төрийг бүрэн утгаар нь байгуулсан билээ. Олноо өргөгдсөн Монгол улсын тулгар төр байгуулагдсан анхны өдрөөсөө төрийн албан хаагчдын боловсролын асуудлыг машид чухалчилан ажилласан байдаг. Үүний үрээр одоогийн манай төрийн албаны сургалт, зөвлөх үйлчилгээний үндэс суурь тавигдсан билээ.

100 жилийн өмнө төрийн албан хаагчдыг бичиг үсэгтэй болгох ажлаар эхэлж байсан Монгол улсын төрийн албаны сургалтын байгууллага өнөөдөр орчин үеийн удирдлагын шинжлэх ухааны сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгааны үндэсний хэмжээний, хүлээн зөвшөөрөгдсөн академи болж өсчээ. Эдүгээ тус Академи төрийн болон бизнесийн бүх байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгаагаараа дамжуулан Монголын төрийн бодлого, үйл ажиллагаа, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөр хэнтэй ч зүйрлэшгүй жинтэй хувь нэмэр оруулдаг институци болон бэхжсэн байна. Олон улсын түвшинд ч Удирдлагын академийг хүлээн зөвшөөрч, бид олон орны ижил төстэй байгууллагууд, бусад их, дээд сургуулиудтай амжилттай хамтран ажиллаж байна.

Удирдлагын Академи бол тусгаар улсынхаа төр, аж ахуйн байгууллагууд, түүний удирдах ажилтныг эрдэм боловсролоор дэмжих гэсэн үе үеийн төрийн бодлого, үйл ажиллагааны үр дүн, өнөөг хүртэлх олон үеийнхний хүсэл эрмэлзлэл, нөр их хөдөлмөр, хүчин зүтгэлийн үр дүн яах аргагүй мөн билээ. Удирдлагын академи байгуулагдсан цагаасаа хойш төр-нийгмийн тогтолцооноос хамааран удаа дараа өөрчлөгдөж байсан ч тусгаар улсынхаа төрийн захиргааны байгууллагууд, түүний удирдах ажилтныг улс төрийн ямар ч тогтолцоо, үзэл суртлаас үл хамааран эрдэм боловсролоор дэмжих гэсэн үндэсний эрх ашгаас хэзээ ч зөрөөгүй явж ирлээ. Удирдлагын академи бол Та бидний, Монгол улсын бахархал мөн.

Далай их дээдсийн гэгээн үйлс Академи минь
Дандаа энхжиж, үүрд мөнхжин мандтугай
Билэг эрдэм, биеийн хүч, бүхий л чадлаараа
Бүтээсэн Академиа мандуулан бадраая.



Богд Хаант Монгол Улс (1911-1921)

Төрийн далбаа



Монгол Улсын төрийн сүлд,
далбаа 1911 он

Богд хааны зарлиг
/Зураг- Монгол бичгээр,
шинэ хуучин үсгээр/



Богд хааны зураг

Улсын дээд, доод хурлаас гаргасан тогтоол
/хуучин монгол, шнэ
үсгээр зураг хэлбэрээр оруулах

Шинэ цагийн манлайлагч бэлтгэх сургууль (1921-1941)



Монгол Улсын төрийн далбаа, 1924 он

Намын төв сургууль анх 1924 онд Монгол Улсын сүүлчийн хаан Богд Жавзундамбын зуны лаврин буюу Хайстайн ордонд хичээллэж эхэлсэн юм. Тус сургууль нам, улсын төв сургууль болон өөрчлөгдөн 1941 хүртэл ажиллахдаа энэ цогцолборт үйл ажиллагаа явуулж байв.



Намын төв сургуулийг үндэслэгчид:

- МАХН-ын дарга Ц.Дамбадорж
- Ерөнхий сайд Б.Цэрэндорж
- Улсын бага хурлын тэргүүлэгчдийн дарга П.Гэндэн





Намын Шинэ хүчний дээд сургууль (1941-1953)



Энэхүү зураг дээрх МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчид 1941 оны 7 дугаар сарын 24-ны хурлаараа Шинэ хүчний дээд сургуулийг байгуулж, 60 оюутантайгаар анх нээлтээ хийжээ.



МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн 1943 оны 16 тоот тогтоолоор тус сургуулийг Д.Сүхбаатарын нэрэмжит болгон шийдвэрлэсэн. 1990 онд Улсын бага хурлын шийдвэрээр энэхүү нэрэмжит өргөмжлөлийг хэрэглэхийг зогсоосон юм.



Тус сургууль байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарилгаар 1974 онд Сүхбаатарын одонгоор шагнав.

Намын дээд сургууль (1954-1959)



Ч.Сүрэнжав
1941-1953 онд ШХДС, 1959-1960 онд Эдийн засгийн дээд сургуулийн захирал



Б.Хурматбек
1964-1980 онд Намын дээд сургуулийн захирал



Г.Миезгомбо
1980-1990 онд Намын дээд сургууль, 1990-1991 онд АИХ-ын дэргэдэх Улс төрийн дээд сургуулийн захирал



МАХН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга, нам төрийн нэрт зүтгэлтэн **Ю.Цэдэнбал** 1941-1950- аад онд тус сургуульд улс төрийн эдийн засгийн ухааны багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байв.



АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга **Ж.Самбуу** 1943-1947 онд тус сургуулийг дүүргэсэн юм.



МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга **Ж.Батмөнх** 1953-1957 онд тус сургуульд багшилж байв.




Академич **Б.Сэрээтэр**
1960-1962 онд
ЭЗДС-ийн захирал

Эдийн засгийн дээд сургууль (1959-1962)




МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1959 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар Намын дээд сургуулийг Эдийн засгийн дээд сургууль болгон өөрчлөн байгуулж, дөрвөн жил ажиллуулахдаа төр, аж ахуйн удирдах ажилтан сурган бэлтгэх ажлыг эхлүүлж байв.



Улс төрийн дээд сургууль (1990-1991)

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 64 дүгээр тогтоолоор Намын Дээд Сургуулийг өөрчлөн, түүний суурин дээр АИХ-ын дэргэдэх Улс төрийн дээд сургуулийг байгуулжээ.



Төр, нийгмийн судлалын Академи (1992-1994)



Улсын бага хурлын 1991 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 44 тоот тогтоолоор Төр, нийгмийн судлалын академийг байгуулсан.

Монгол улсын гавьяат багш, доктор, профессор **Я.Долгоржав** 1991-1994 онд Улсын бага хурлын дэргэдэх Төр, нийгмийн судлалын академийн захирлаар ажиллажээ.

Монгол улсын Засгийн газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт (1994-1999)




Ц.Адьяа
доктор, профессор
1994-1996 онд
ажиллаж байсан.



Ц.Гомбосүрэн
Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш 1996-1998 онд
ажиллаж байсан.

ТЗУХИ



Захирлууд



Я.Долгоржав
Доктор, профессор

Захирлууд



Д.Бямбасүрэн
Доктор, профессор,
гавьяат эдийн засагч

Захирлууд



К.Зардыхан
Доктор, профессор



Д.Цэрэндорж
Доктор, профессор



С.Нямзагд
Доктор, профессор шинжлэх
ухааны гавьяат зүтгэлтэн



Д.Цолмон
Доктор, профессор




Д.Сэржамц
Доктор, профессор





Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи

Монгол улсын Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 197 тоот тогтоолоор ТЗУХИ-ийг өөрчлөн Удирдлагын Академийг байгуулав.



Удирдлагын академийн захирлууд



Д.Бямбасүрэн
Доктор, Монгол улсын
гавьяат эдийн засагч
1999-2000 онд
ажиллаж байсан.



Ш.Түдэв
Доктор, профессор,
Монгол улсын гавьяат багш
2000-2005 онд
ажиллаж байсан.



Т.Лхагваа
Доктор, профессор,
Монгол улсын гавьяат багш
2005-2008 онд ажиллаж байсан.





Г.Чулуунбаатар
Академич, доктор, профессор
2008-2012 онд ажиллаж байсан.



Ц.Баатартогтох
Доктор, профессор
2012 оноос ажиллаж байна.

Удирдлагын академийн зохион байгуулалтын бүтэц 2014 он





Алсын хараа

Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, дотоодын ижил төрлийн сургалт, судалгааны байгууллагуудын дунд тэргүүлэх байр суурьтай мэдлэг оюуны төв байх.

Эрхэм зорилго

Манлайлан удирдах чадвартай удирдах ажилтныг бэлтгэх, удирдахуйн зангилааа суудлуудаар судалгаа хийх, зөвөлгөө өгөх ажлыг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинжлэх ухааны орчин үеийн онол-арга зүйн төвшинд гүйцэтгэх.

Удирдлагын Академийн хүндэт докторууд

1999	Нацагийн Багабанди	Монгол Улсын Ерөнхийлөгч
1999	Ринчингийн Амаржаргал	Монгол Улсын Ерөнхий сайд
2001	Киокичи Хироно	Япон Улсын профессор
2002	Стефен Даннетт	АНУ Нью-Йоркийн Их сургуулийн профессор
2002	Намбарын Энхбаяр	Монгол Улсын Ерөнхий сайд
2002	Ёохей Сасакова	Японы “Ниппон”сангийн ерөнхийлөгч
2005	Егоров Виктор Константинович	ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэрэгдэх Төрийн захиргааны академийн ерөнхийлөгч
2005	Ли Квон Сан	БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтын ерөнхийлөгч
2006	Чан Мо Сан	Инжегийн их сургуулийн ерөнхийлөгч
2006	Эдгар Портер	Хавайн их сургуулийн профессор
2011	Дитер Вагнер	ХБНГУ-ын Потсдамын их сургуулийн дэд захирал
2014	Мартин Поу	Канад улсын зөвлөх үйлчилгээний Делойтт Онч байгууллагын олон улсын зөвлөх
2014	Цахиагийн Элбэгдорж	Монгол улсын ерөнхийлөгч

Удирдлагын Академийн хүндэт профессор

1999	Раднаасүмбэрэлийн Гончигдорж	Монгол Улсын Их Хурлын дарга Намын дээд сургуульд ажиллаж байсан, доктор, профессор
1999	Сандаг-Очирын Жалан-Аажав	Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтын захирал.
1999	Ломбоцэрэнгийн Гүржав	Шинжлэх ухааны доктор, профессор
2006	Гомбын Миеэгомбо	Намын дээд сургууль, Улс төрийн дээд сургууль, Төр, нийгмийн судлалын академийн захирал
2007	Ричард Пратт	АНУ-ын Хавайн их сургуулийн Төрийн удирдлагын хөтөлбөрийн захирал



Одоо ажиллаж буй гавьяат багш нар



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **Я.Шуурав**



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **Я.Долгоржав**



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **Б.Намсрай**



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **П.Увш**



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **Ш.Түдэв**



Доктор, профессор,
Монгол улсын гавьяат
багш **Т.Лхаваа**



Захиргааны зөвлөл

Уг Академийн захиргааны зөвлөл нь захирлын шийдвэр гаргах үйл ажиллагаанд зөвлөх үндсэн үүрэгтэй. Захиргааны зөвлөл нь Академийн хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөгөөг хэлэлцэх, сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлийг хэлэлцэх, академийн хэмжээнд нийтлэг үйлчлэх журам, түүний биелэлтийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эрдмийн зөвлөл



Эрдмийн зөвлөл нь академийн судалгаа, зөвлөх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлох, академийн судалгааны ажлыг үнэлэх үндсэн үүрэгтэй. Эрдмийн зөвлөл нь эрдэм шинжилгээний бодлого, үндсэн чиглэл, төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэж батлах, эрдэм шинжилгээний бүтээлийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах, эрдмийн цол олгох зэрэг асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.



Сургалтын алба

Сургалтын бодлого төлөвлөх, нэгдсэн зохицуулалт хийх, сургалтын үйл явцыг технологийн дагуу зохион байгуулах үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Сургалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, сургалтын технологи, стандартыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих, багш нарын ажлын гүйцэтгэлийг тооцож, үнэлэх хичээлийн хуваарийг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт тавих, суралцагчдын дүнгийн нэгдсэн бүртгэл тооцоо, холбогдох мэдээ, тайланг гаргах зэрэг чиг үүрэгтэй ажиллаж байна.



Зохион байгуулалтын алба

Тус алба нь Удирдлагын академийн захиргааны өдөр тутмын ажлыг зохион байгуулах, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй.





Удирдахуйн Ухааны сургууль

Удирдахуйн ухааны сургууль (УУС) Төрийн захиргааны менежмент (Public Administration Management), Нийтийн удирдлага (Public Management), Бизнесийн удирдлага (Business Administration), Менежмент (Management) гэсэн мэргэжлийн чиглэлээр магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэн явуулж байна.

Магистрын сургалтад өдрийн хэлбэрээр элсэн суралцагч 1,5 жилд, гараг, улирлын хэлбэрээр суралцагч 2 жилд 30-32 багц цаг хичээл судалж төгсөнө. Докторын зэрэг олгох сургалтын үргэлжлэх үндсэн хугацаа 3 жил. Докторант 60 багц цагийн сургалт, судалгааны ажил гүйцэтгэнэ. Тус сургуулийн хүрээнд баклаварын сургалт явуулдаг захиргааны сургууль ажилладаг.



Төрийн алба, удирдлагын сургууль

Төрийн алба, удирдлагын сургууль нь боловсролын бакалаврын зэрэгтэй хүмүүсийг төр, бизнес, нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх, мэргэшил дээшлүүлэх, давтан сургах танхимын болон зайн сургалтыг эрхлэн зохион байгуулах үндсэн үүрэг бүхий Удирдлагын академийн бүрэлдэхүүний сургууль юм.

Тус сургууль мэргэшүүлэх сургалтыг албан тушаалын ангилал, зэрэглэлд нийцүүлэн диплом, сертификатын түвшинд гараг, улирал, өдрийн хэлбэрээр зохион байгуулдаг.

Төрийн алба, удирдлагын сургуульд төр, төрийн бус, бизнесийн байгууллагад одоо ажиллаж буй болон цаашид ажиллахаар өөрийгөө бэлтгэж буй иргэнийг төр, бизнес, нийгмийн удирдлагын мэргэшлийн хүрээнд тодорхой чиглэлээр гүнзгийрэн мэргэшүүлж, байгууллагын удирдах албан тушаалд ажиллахад шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшүүлж бэлтгэдэг.



Мэргэшил дээшлүүлэх институт

Төрийн албан хаагч, байгууллагын удирдах ажилтны мэдлэг чадварыг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэхэд чиглэсэн богино хугацааны сургалтыг зохион байгуулах үүрэгтэй. Богино сургалт нэг өдрөөс дөрвөн долоо хоногийн хугацаанд орон нутаг, ажлын байранд болон Удирдлагын академид зохион байгуулагддаг.



Засаглалын судалгаа, зөвлөх үйлчилгээний хүрээлэн

Засаглалын судалгаа, зөвлөх үйлчилгээний хүрээлэн нь олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн захиалгаар төсөл боловсруулах, хэрэгжүүлэх замаар зөвлөх үйлчилгээг академийн хэмжээнд зохион байгуулах, академийн сургалт, эрдэм шинжилгээ, санхүүгийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй бүрэлдэхүүн сургуулийн статус бүхий бүтцийн нэгж юм.



Төрийн удирдлагын тэнхим



Захиргааны шинжлэх ухааны чиглэлээр сургалт, судалгаа эрхлэн явуулдаг бөгөөд төрийн удирдлагын салбарт хамрагдах 20 гаруй хичээлийг хариуцан зааж байна.

Төрийн удирдлагын тэнхимд захиргааны шинжлэх ухаан, төрийн бодлого, төрийн алба, нутгийн удирдлагын чиглэлээр Монголдоо тэргүүлэх эрдэмтэн, багш, судлаачид ажилладаг. Төрийн удирдлагын тэнхим нийт 20 багштай, үүнээс 76 хувь нь доктор, профессор зэрэгтэй. Тэнхимийн багш нарын 60 хувь нь гадаад орнуудад суралцаж магистр, докторын зэрэг хамгаалсан.

Менежментийн тэнхим

Стратегийн удирдлага, удирдлагын ерөнхий онол, байгууллагын хөгжил манлайлал, хүний нөөцийн удирдлага, төсөл хөтөлбөрийн удирдлага, чанар болон бүтээмжийн удирдлага, эрсдэлийн удирдлага, компанийн засаглал ба олон улсын менежмент, инновацын чиглэлээр сургалт, судалгаа, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулж байна.



Хэлний тэнхим

Хэлний тэнхимийн үйл ажиллагааны зорилго нь насанд хүрэгчдийн онцлогт тохирсон хэлний хичээл заах онол, арга зүйн судалгаа хийх, хэлийг суралцагчдад хэрэглээний хэрэгсэл болгон эзэмшүүлэхэд чиглэж байна. Франц, Англи хэл, албан хэрэг хөтлөлт, судалгааны бичлэг зэрэг хичээлийг хариуцан заадаг. Хэлний тэнхим нийт 6 багштай, судалгааны туслах ажилтан 1 ажиллаж байна.





Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхим

Хүний хөгжилд чиглэсэн нийгмийн чанартай үйлчилгээг зохион байгуулж, удирдах чадвартай ажилтан бэлтгэхэд үйлчлэх, сургалт, судалгааны нэгж байхад тэнхимийн зорилго оршиж байна.

Нийгмийн суурь болон хавсрага судалгаа хийж, сургалтын агуулга боловсруулж, нэвтрүүлэх, нийгмийн салбарын удирдлагын чиглэлээр ном, сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, улс төрийн орчины талаарх судалгаа хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй.



Эрх зүйн тэнхим

Эрх зүйн тэнхим нь “хуульч”-ийн эрхтэй эрх зүйч мэргэжлийн багш нараас бүрддэг. Тэнхим нь төр, бизнес, нийгмийн чиглэлийн бүх шатны сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдсан нийтийн (Үндсэн хууль, төр захиргааны эрх зүй гэх мэт) ба хувийн (бизнесийн, иргэний хөдөлмөрийн эрх зүй гэх мэт) эрх зүйн салбарын хичээлийг хариуцан заадаг.

Эдийн засаг, санхүүгийн тэнхим



Эдийн засаг, санхүүгийн тэнхим нь тус Академийн суурь болсон 70 орчим жилийн түүхтэй Эдийн засгийн онолын тэнхимийн суурин дээр байгуулагдсан. Эдийн засаг, санхүүгийн тэнхим эдийн засгийн бодлого, төрийн болон бизнесийн байгууллагын санхүүгийн удирдлага, маркетингийн чиглэлээр удирдах ажилтны эрэлт хэрэгцээ, улс орны хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн чанартай сургалт явуулж, судалгаа хийх, бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг. Эдийн засаг, санхүүгийн тэнхим 14 багш, 2 ажилтантай, багш нарын 70 гаруй хувь нь докторын зэрэгтэй, 65 хувь нь өндөр хөгжсөн оронд магистр, докторын зэрэг хамгаалсан.



Социологи, сэтгэл зүйн тэнхим

Социологи, сэтгэл зүйн тэнхимийн эрхэм зорилго нь удирдах үйл ажиллагааны нийгэм-сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт, эрэлт хэрэгцээг үндэс болгон эрдэм шинжилгээ, сургалт, зөвлөх үйлчилгээний ажлыг чанартай зохион байгуулж, сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж төлөвшүүлэхэд оршино. Тэнхимд 8 багш 2 ажилтан ажиллаж байна.



Мэдээллийн технологийн төв

Сургалтын болон мэдээллийн техник хэрэгслийг ажиллуулах, хяналт тавих, дотоод, гадаад сүлжээний ажиллагааг хариуцах, бүх төрлийн сургалтын болон судалгааны программыг компьютерт суулгах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ.



Номын сан

Академийн номын сан 1925 онд Намын дээд сургуулийн дэргэд “Ном зүйн тасаг” нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн, Монгол улсын дээд боловсролын байгууллагын анхны номын сан юм.

Уншлагын 3 танхим, эрдэм шинжилгээний танхимаас бүрдсэн 220 суудалтай.

Жилд дунджаар давхардсан тоогоор 35148 уншигчдад 60000 гаруй ном, сурах бичиг, гарын авлага, тогтмол хэвлэлээр үйлчилдэг.

Цахим хэлбэрээр ном, хэвлэлийг унших боломж нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. JSTOR, OECD-ilibrary, Edward Elgar Journals, Ebooks, IMF eLibrary, BioOne зэрэг гадаад хэл дээрх мэдээллийн сан болон тогтмол хэвлэл, үндэсний статистикийн газрын багц мэдээллээр уншигчдад үйлчилэхээс гадна уншлагын танхим, гэрээр ном олгох, лавлагаа мэдээлэл өгөх, хувиан олшруулах үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна.



Санхүү, үйлчилгээний алба

Санхүү, үйлчилгээний алба нь академийн хэмжээнд санхүү, аж ахуйн ажил, үйлчилгээ үзүүлэх үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Нягтлан бодох бүртгэлийг нийтлэг журам, стандартын дагуу хөтлөх, байгууллагын аж ахуйг эрхлэн хөтлөх чиг үүргийг хүлээнэ.





Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Сургалт зохион байгуулах, судалгаа хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, багш, судлаач, оюутан солилцох, сургалт, судалгааны материал солилцох зэрэг үйл ажиллагааг хамтын ажиллагаа, гадаад харилцааны хүрээнд зохион байгуулдаг.



Удирдлагын Академитай хамтын ажиллагаатай сургуулиуд



- Австрийн Клагенфуртын Алпен Адриа их сургууль



-БНХАУ-ын Удирдлагын академи, ӨМӨЗО-ны Багшийн их сургууль, Нефтийн их сургууль



-Франц улсын Үндэсний захиргааны сургууль



-ХБНГУ-ын Потсдамын их сургууль



-Японы Рицумейкан Ази Номхон далайн их сургууль



-БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институт, Жендэрийн тэгш байдал, боловсролыг дэмжих институт, Геонгигийн эмэгтэйчүүдийн хөгжлийн төв, Инже их сургууль, Дэгү их сургууль, Олон улсын Бизнесийн дээд сургууль



-Тайландын Хөгжлийн үндэсний институт



-АНУ-ын Хавай их сургууль, Вашингтон мужийн Бэлинхэмийн Баруун Вашингтоны их сургууль, Кентаки их сургууль (University of Kentucky)



- Их Британи Умард, Ирландын Нэгдсэн Вант Улсын Кембрижийн их сургууль, Төрийн албаны коллеж



БНХАУ-ын Олон Улс судлалын их сургууль, АНУ-ын Нью Йоркийн Баффалогийн их сургууль, ХБНГУ-ын Шпайерийн их сургууль, Тайландын Маастрихын их сургуулийн Хүн ам, нийгмийн судалгааны институт, Энэтхэгийн Ранчи их сургуулийн Хүн ам судлалын олон улсын институт, Бизнесийн удирдлагын институт, Шведийн Төрийн захиргааны институт, Уппсалагийн их сургууль, Голландын Махаришийн их сургууль, Австралийн Куртины их сургуулийн олон улсын англи хэлний төвтэй тодорхой хугацаанд хамтран ажиллаж байсны зэрэгцээ зарим сургуулиудтай хамтын ажиллагаагаа албан бус хэлбэрээр үргэлжлүүлэн ажиллаж байгаа болно.

Удирдлагын академи нь олон улсын байгууллага НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Ханс Зайделын сан, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг болон Монгол улс дахь АНУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, ОХУ, Энэтхэг улс, Канад улс, Франц улсын Элчин сайдын яамдуудтай хамтран ажилладаг.





